

Монгол үндэсний арьсан урлалын дизайнд урлагийн уламжлалт элементүүдийг тусгах туршилт судалгаа

Ү.Мэргэн*

Өвөр Монголын Үндэстний Их Сургууль,
Урлагийн дээд сургууль, Үндэсний гар урлалын тэнхим

Хураангуй

Арьсан урлал бол соёл урлагийн чухал салбар төдийгүй Монгол үндэстний уламжлалт гар урлалын нэг юм. Цаг үеийг даган шинэчлэгдэн хөгжсөөр өнөөг хүржээ. Монголын уран бүтээлчид дэлхийн зах зээлд өөрийн соёлыг сурталчлах өвөрмөц бүтээлүүдийг урласаар байна.

Шандан, 2010, Монгол үндэстний арьс ширэн урлагийн өв залгамжлал, хөгжил, Жао Жен Лон, 2012, үндэстний соёл, гар урлал, хэрэглэхийн чадвар, үнэ өртөг судалгаа, Бай Сарнаа, 2013, Монгол үндэстний уламжлалт арьсан эдлэл хийгээд нүүдэлчин соёлын харьцаа холбоо, худалдааны бараа таваарын нөлөө тусгал зэрэг судалгаанууд хийгдсэн байна. Гэсэн ч дизайны онол үзэл баримтлал, үндэсний уламжлалт элементийн хэрэглээ хомс, багаж хэрэгслийн шинэчлэлт харьцангуй удаан зэрэг дутагдалтай зүйлс нэлээд байна. Монгол үндэстний арьсан урлагийн бүтээлүүд дэх уламжлалт элементүүд, багаж хэрэгслийн шинэчлэл, дизайны шинэлэг санаа гэсэн гурван талаас онолын эх материал судалж, түүнд суурилсан “Үргэлжлэл”, “Эх”, “Арьсан гар урлал-амьдралын чимэг” гурван цуврал шинэчилсэн бүтээл хийж туршив. Эдгэр бүтээлийг хичээлийн хэрэглэгдэхүүн болгож ашиглаж мөн дотоод гадаадын үзэсгэлэнгүүдэд оролцож, Монгол үндэсний арьсан урлалын дизайныг боловсронгуй болж, бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж хөгжих боломжийг судалсан болно.

Түлхүүр үг

Монгол үндэстний арьсан урлаг, дизайны үзэл баримтлал, шинэчлэл судалгаа, уламжлалт элемент, багаж хэрэгсэл, уламжлалт гар урлал

Удиртгал

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий Газраас “Хятадын уламжлалт гар урлалыг сэргээн хөгжүүлэх төлөвлөгөө”-г 2017 оны 03 дугаар 27-ны өдөр баталсан. Мөн Соёл, Аялал Жуулчлалын Яамнаас “Соёлын аж үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл”-ийг 2018 оны 06 дугаар сарын 28-нд нийтэд танилцуулж, “Төрөөс уламжлалт гар урлалыг өвлөн хамгаалах, хөгжүүлэх, шинэ санаачилгыг дэмжиж, гар урлалыг орчин үеийн техник технологи, бүтээлч дизайнтай хослуулах”-ыг уриалсан. Бид 2018 оны 12 дугаар сард “Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн шинжлэх ухааны судалгааны сангийн төсөл” (дугаар: nmduyb17201) батлуулсан. Энэхүү төслийн хүрээнд баримт бичиг судлан Монгол үндэстний арьсан урлалын үзэл санаа, сэтгэлгээнд анализ хийж, Монгол үндэстний арьсан урлалыг баяжуулах судалгааг хийсэн болно.

Судлагдсан байдал

БНХАУ-ын Монгол үндэсний арьс, ширэн урлалын судлагдсан эх сурвалжаас үзвэл: 2010

онд Шанданы⁴⁹ “Монгол үндэсний арьсан биет урлагийн судалгаа”-даа Монгол үндэстний уламжлалт арьс ширэн урлагийн гоо зүйн үнэ цэнэ, орчин үеийн арьс ширэн урлагийн онцлог шинж чанаруудыг дэлгэн харуулахаар Монгол үндэстний арьс ширэн урлагийн өв залгамжлал, хөгжлийн талаар судалсан байна.

2012 онд Өвөр монголын Багшийн их сургуулийн Жао Жен Лонын⁵⁰ “Өвөр Монголын арьсан сийлбэр урлалын жуулчны бэлэг дурсгалын загвар, хэрэглээ” судалгаандаа Өвөр Монголын арьсан урлал бүхий дурсгалт бүтээлийг дэлгэрүүлэн хөгжүүлэх боломжийг дурдаснаас гадна одоо үеийн төсөөллийн онол болон арга барилыг хэрэглэж үндэстний соёл, гар урлал, хэрэглэхийн чадвар, үнэ өртөг судалгааг хийсэн байна.

2013 онд Бай Сарнааны⁵¹ “Монгол үндэстний уламжлалт арьсан эдлэлийг үйлдвэрлэх ур мэргэжил түүний гоо сайхны онцлог” судалгаандаа Монгол үндэстний уламжлалт

*Холбоо барих зохиогч: morigen6666@163.com

⁴⁹山丹

⁵⁰赵振龙

⁵¹白萨日娜

арьсан эдлэл хийгээд нүүдэлчин соёлын харьцаа холбоо, худалдааны бараа таваарын нөлөө тусгалыг судалж, мөн гар урлалаар арьсан эдлэл хийх талаар судалгаа хийжээ.

Бао Гүй Инийн бичсэн “Нүүдэлчин үндэстний ангийн арьс, ширэн урлал”, Цао Лийн⁵² “Ба Вэй Лий арьсан биет урлагийн бүтээл”, Ван Пен Рүйн⁵³ “Японы орчин үеийн арьсан гар урлал хийхэд Монгол үндэстний арьсан гар урлалын уялдаа холбооны талаарх судалгаа”, Хэ Фангын⁵⁴ “Арьсан урлалаас Монгол үндэстний засал чимэглэлийн хээ угалзыг шинжих нь”, Оюуны⁵⁵ “Монгол үндэстний бүслүүрийн хувьсал хийхэд түүний соёлын агуулга” зэрэг судалгаанууд монгол үндэстний арьс ширэн урлалын түүх, орчин үе, Японы арьс ширэн урлал хоорондох холбоо зэрэг талаас нь судлагдсан байна. Гэтэл Монгол үндэстний арьс ширэн урлалын дизайнд үндэстний урлагийн уламжлалт элементүүдийг тусгах, онол ба практикийг харилцан уялдуулсан туршилт судалгаа хийгдээгүй байна.

Судалгааны арга зүй

Бид энэхүү судалгааны ажлыг 2 жилийн хугацаанд 3 дээд сургуулийн 40 оюутан, 16 багш, гар урлаачдыг хамарсан судалгаа явуулж, баримтын задлан шинжилгээ, ажиглалт, ярилцлага, загварчлал, гар урлал зэрэг аргуудаар хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны үр дүн

Судалгааг арьсан урлалын багажийн шинэчлэл, Арьсан урлалын ба уламжлалт элементийн уялдаа, Арьсан урлалын дизайны үзэл баримтлалын шинэлэг санааг тус тус дэвшүүлж, үр дүнг гаргасан болно.

1. Арьсан урлалын багажийн шинэчлэл


Арьсан урлалын багаж нь гар аргаар бүтээсэн тул давуу болон сул талтай. Гараар үйлдсэн учраас хийцийн хувьд нарийн биш, тоо ширхэг цөөн, материал нь төгс биш гэх мэт сул талтай.

Монгол үндэстний арьсан урлалын хөгжилд өвөрмөц сайн багаж шинэчлэн бүтээж, олон тоогоор үйлдвэрлэх шаардлагатай байна. Арьсан урлаачийн хувьд багаж хэрэгсэл нь өөрийн дотоод бодол, сэтгэлгээг бүтээлд тусгахад гол хэрэгсэл болж гарт тохирсон сайн багаж нь төгс төгөлдөр бүтээлийг амжилттай бүтээхэд

тусалдаг. Бид Монгол хээ угалзын хоёр талыг тасралтгүй гүйцээхийг үндэслэж, хээг халааж дарах багажийг зохион бүтээсэн (Зураг 1). Энэ зохион бүтээх үйл явцаар дамжиж Монгол үндэстний арьсан урлалын багаж хэрэгслийн шинэчлэлийн туршилт хийхийг зорьсон.

Зураг 1

Шинэчилсэн багаж хэрэгсэл




2. Арьсан урлалын ба уламжлалт элементийн уялдаа

2.1. Хатгамлаас санаа авсан бүтээл

Өндөр настангуудтай уулзан Хорчины хатгамлын ур чадварт суралцан (Зураг 2, 3). бүтээлийн дизайныг сэтгэн бодохын зэрэгцээ Хорчин хатгамлыг арьсан дээр урлах туршилт хийснээр Хорчин хатгамал болон арьсан урлаг нь өөрийн гэсэн хэв маягтай, тэдний дотоод мөн чанарт нь эрхэмсэг онцлог шинжүүд хадгалагдаж байдгийг олж мэдсэн. Даяарчлалын эринд бид Монгол үндэстний уламжлалт үзэл санаа, зан үйл, оюун ухаан, ур мэргэжил, хэллэгийг арьсан урлалын бүтээлдээ уламжлалт онцлогтой, өнөөгийн цаг үед тохирсон урлагийн бүтээл бий болгохыг хичээж байна.

Зураг 2, 3

Хорчины хатгамалтай тамхины уут, Хорчины хатгамлын ур мэргэжил



“Үргэлжлэл” бүтээл (Зураг 4)-ийг Хорчин хатгамал хийгээд арьсан урлагтай уялдуулан бүтээсний учир: хийсвэр, бодит зураг дүрс нь тал нутгийн соёлын хөг аяс болон Монгол бүсгүйчүүдийн борогжуун ажилч, сайн сайхан амьдрал хүсэмжилсэн үзэл санааг шингээсэн юм. Хорчин хатгамал нь өнө удаан түүхтэй, төрөл

⁵²曹莉

⁵³王鹏瑞

⁵⁴何方

⁵⁵乌云

зүйл олон, агуулга баялаг, өнгө ялгарам эрхэмсэг байж, Монгол үндэстний соёлын өвөрмөц тогтолцоог бэлгэддэг.

Зураг 4

Үргэлжлэл бүтээл



“Үргэлжлэл” бүтээлийн практик ажиллагаанд хатгамлыг нимгэн, зөөлөн материал дээр хийх шаардлагатай тул элдсэн зөөлөн 0.8-2 мм нимгэн үхрийн арьсан дээр цэцгэн хатгамалтай зураг сонгосон нь баялаг зохиомжтой болсон. Хатгамлын явцад нягт хатгахад арьс цоорч гэмтээхээс болгоомжилж арьсны ар талд даавууг жонхуу (даавуу, цаас зэрэг нимгэн юм наахад зориулан буцалгасан шингэн гурил)-гаар наав (зураг 5, 6). Бүтээлээ цогц болгохын тулд тусгайлан олон зураастай арьсыг сонгосон. Хатгамлын ажил дууссаны дараа дэвсгэр хэсгийг өнгийн будгаар хөнгөн зурснаар зураг, дүрсийг улам амьдлаг болгон, зохимжтой багаж хэрэгслийг сонгон монгол үндэсний хээ угалзыг сийлэн чимэглэсэн. (Зураг 7, 8). Ингэснээр Монгол үндэстний хээ угалз нь Хорчин хатгамалтай зохицон нэгэн цогц бүтээл бий болсон юм.


Зураг 5, 6

Даавуу наах, жонхуу



Зураг 7, 8

Дэвсгэр хэсгийг зурах, арьсан сийлбэр ур мэргэжил



2.2. Хадан зургаас санаа авсан бүтээл

“Эх” (Зураг 9) бүтээлийг дараах сэдвээс үндэслэн зохион бүтээсэн. Төмөр зэвсгийн цаг үед Алшаагийн баруун хошууны Мандал уулын “Зэрлэгүхэр”, “Морьтон” хадны зураг, Хишигтний Лио Улсын үеийн “Язгууртан морьтон” зэрэг гурван хадны зургийг үндэслэв. Гурван хадны зургийг уялдуулан арьсан чимэглэлийн цуврал бүтээл нь чимэглэх урлагийн төрөлд багтана.

Бүтээл нь зургийн бүтцийн хэлбэр болон зохион бүтээх сэтгэлгээтэй салшгүй холбоотой. Бид “Морьтон” бүтээлийг гурван зургийн дунд байрлуулснаар бүтээлийг тэнцвэртэй болгон, цуврал зургийн агуулга, бүтэц болон хэлбэрт зохицон харааны хүртэхүйд таатай. 3 мм-ийн зузаан үхрийн ширээр бүтээл хийсэн нь зураг дүрсийн хотгор, гүдгэрийг сийлж гаргахад тохиромжтой байлаа. Хадны зургийн зураас, фактурыг гаргахын тулд үрчгэр, нугалаатай арьсыг сонгож, будаг оруулж зургийн харагдах байдлыг сайжруулсан. Хадны зураг болон арьсан урлагийг хослуулсан бүтээлдээ үхрийн арьсны өөрийнх нь зураасыг гүйцэд ашиглан, хадны зургийг сийлэх, болон үрэх аргыг ашиглаж “Эх” бүтээлийг туурвисан нь язгуураа умартаж болохгүй гэсэн үзэл санааг бүтээлдээ тусгахыг зорьсон.

Зураг 9

“Эх” хадны зургийн цуврал бүтээл



Өвөр Монголын хадны сүг зургийн агуулга, хэлбэрээс тал нутгийн нүүдэлчдийн аж ахуй, оюун ухааны үнэн бодит зураглал бөгөөд Монгол үндэстний түүхэн ул мөр, соёл иргэншлийн үүсэл гарлыг тэмдэглэн тоочсон байна. Бидний олж харсан хадны зураг бол балар эртний урлагийн уг дүр болно. Балар эртний урлаачид хадны зургийг зурахдаа орчин тойрноо ажиглан харж зурах биш өөрийн оюун ухаандаа түшиглэн зурдаг байсан.

Балар эртний хадан зургууд хэтрүүлэгтэй бөгөөд дүрс нь хувирсан амьтныг зураглаж үзэхэд, сэрлээс сэдэлт олсон шиг, энгийн сэрлээс давж, нэг зүйлийн хийсвэрлэсэн дүрсээр өөрийн бодол саналаа цухуйлгав (Амарбат, 2008, х.13). Иймэрхүү дүрс болон бодол санаа нь хадны зургийн судлаачид болон урлаачдын дотоод сэтгэлгээг маш их хөндөж байна. (Зураг 10, 11)

Зураг 10, 11



Эх сурвалж: *Зэрлэг морь сургах* (Н. Далангурав, 2000, х.53)

Эх сурвалж: *Ан агнах* ((Н. Далангурав, 2000, х.103)

Арьсан урлалын дизайны үзэл баримтлалын шинэлэг санаа

Бид “Хамар” болон “Эвэр” хээн чимэглэлийн дүрсээс сэдэвлэн, орчин үеийн эмэгтэйчүүдийн эдлэл, цуврал арьсан бүтээлийг зохион бүтээв. Үүнд: эмэгтэй хүний гар цүнх, түрийвч, гар утасны гэр, бүс, түлхүүрийн гэр болон бугуйвч зэрэг юм.

Бүтээлийн дизайны хувьд энгийн, тухтай байдлыг анхаарч, өнгө будгийн хувьд арьсны өөрийн байгалийн өнгийг хадгалж, дэгжин хээнцэр, борогжуу, эелдэг зөөлөн байдлыг илэрхийлэхийг зорьсон. Хэрэглээний талаас бид гар урлалын хэрэгцээт чанар болон гоо сайхны таашаалыг хослуулахыг бодолцон, үндэстний онцлог болон хэрэглээний чанарыг голчлон илрүүлж, урлаг дахь өөрийн үзэл санааг шингээсэн болно.

Зураг 12

Арьсан гар урлал, амьдралын чимэг




Бид “Арьсан гар урлал-амьдралын чимэг” (Зураг 12) бүхий цуврал бүтээлийг Монгол үндэстний “Хамар хээ”, “Эвэр хээ” (зураг 13, 14) –ээс сэдэвлэсэн. 3600 жилийн өмнө Шье Жье Даяан доод давхаргын соёл иргэншлийн үеийн өнгөт ваар савны ихэнх нь хамар, эвэр хээ угалзаар чимэглэдэг байсан нь тотем (эрт цагт овог аймгийн сүлд болгон шүтэж байсан амьтан юм) болон өлзий хутгийн санаа агуулдаг (Амарбат, 2008, х.445).

Эдгээр хээ угалз нь амьтны ямар нэг хэсэг бөгөөд Монгол үндэстэн түүхэн урт хугацааны туршид өөрсдийн амьдралд зохицсон хээ угалзыг шилж, сонгон хадгалсны үр дүн болно. Малчин ардын таван хошуу мал олон төл авч, өсөж үржин өнөр болтугай гэх ерөөлийн утгатай.

Зураг 13, 14



Эх сурвалж: *Хамар хээ* (Гүржсав, 2008, х.218)



Эх сурвалж: *Эвэр хээ* (Гүржсав, 2008, х.208)

Малчин ард түмний дунд хамар хээний тухай уламжлагдан ирсэн үлгэр байдаг. Монгол үндэстний хамар болон эвэр хээгээр хоёр талын тасралтгүй үргэлжилсэн хээ, зах хөвөө, өнцөг буланг чимэглэсээр ирсэн нь эртний Хүннү, Сяньби, Киданы үеэс өнөөг хүртэл өргөнөөр хэрэглэгддэг баялаг хээ угалз болсон.

Профессор Улаантуяа “Монгол үндэстний хээ угалзын бүтцийн уг дүрсийн тухай задлалт” өгүүлэлдээ: “Зураг дүрс болон бүтцийн уг дүрсийн харьцаа холбоогоос авч хэлбэл Монгол хээ угалз нь ‘угалз’ бүтцээр цөм болгож, хамар, эвэр хээгээр суурь болгон гадагш өргөтгөн сунасан явц” гэжээ. (Улаантуяа, Хайрхан, 2011, х.45).


Загвар зохион бүтээх: Гараар зурж загвар зохион бүтээх (Зураг 15), компьютероор зурах (Зураг 16), компьютерт зассан сүүлийн хувилбар зураг /rendergraph/ (Зураг 17) зэрэг дарааллаар зохион бүтээнэ. Эхлээд сэтгэмжээ гараар зурж, зохион бүтээх явцдаа чөлөөтэй сэтгэн, загварыг бий болгосон. Загвараа гаргасны дараа зохиомжийн хэмжилт, харьцааг нарийн тооцоолж дахин компьютерт оруулан, жишиг загварыг бий болгов. Жишээлбэл, зургийн эх ноорог нь гар утасны гэрийн их бага харьцааг iphone 4s утасны

хэмжээгээр хийв. Техник технологи тасралтгүй шинэчлэгдэж буй өнөө үед үйлдвэрлэлийн шинэчлэлт хурдацтай явагдаж iPhone 5s, iPhone 6s-ийг үйлдвэрлэх нь цаг хугацааны асуудал болоод байна. Иймээс iPhone 5s-ийн компьютерт оруулсан зургийн ноорог дээр бага зэргийн хэмжээг өөрчлөн iPhone 6s гар утасны гэрийн загварыг гаргах боломжтой. Үүнээс үндэслэн эхний загварыг ашиглан дараа дараагийн загварыг бий болгоход хурдан, оновчтой, нарийвчилсан, бодит хэрэгцээт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж чадна.

Компьютерт зассан сүүлийн хувилбар зураг /rendergraph/ нь бүтээлийн өнгө будаг, дүрс болон эцсийн бүтээмжийг сайн болгодог. Ноорог, эскиз зургийн загварыг чөлөөтэй тохируулж, уран бүтээлчийн бодол санаа, бүтээлч чадварыг гүйцэд гаргаж чадна.

Зураг 15

Гараар зурж загвар зохион бүтээх




Зураг 16

Компьютерээр зурах



Зураг 17

Компьютерт зассан сүүлийн хувилбар



Гараар урлах: Арьсан урлалын цуврал бүтээлийг бүтээхийн тулд гараар урладаг бөгөөд голдуу арьс, ширийг хайчлах, эсгэх, сийлэх, будах, хайчилбар, шигтгээ хийх, оёж урлах (зураг 18-19) зэрэг арга багтдаг. Эдгээр ажиллагааг үе шатаар бүрээр нь гүйцэтгэнээр Монгол үндэстний уламжлалт арьсан урлалын бүтээл төгс болох юм.

“Арьс ширийг хайчилж хээ наахыг, мөн хээ ухах бас сийлбэр хээ гэж нэрлэдэг. Энэ бол арьсыг олон төрлийн сийлбэр хээгээр хайчилж, нэг материал дээр тогтоон наасны дараа оёж урлах нэг зүйлийн чимэглэлийн гар урлал болно” (Цацралт, 2003, х.38). Арьсан хайчилбар нь Лио улс болон Монгол хаант улсын үед өдөр тутмын чимэглэл болж хэрэглэгдэж байжээ. Үүнд голдуу цэргийн хуяг, дуулга болон саадагт хэрэглэгдэж байжээ. Арьсан хайчилбар хээг эмээлийн гөлөмд наадаг нь өнөөг хүртэл хэрэглэгдсээр гоо сайхны урлагийн түвшинд хүрсэн. Арьсан хайчилбар хээг наах нь бүтээлийг эмх цэгцтэй, чамин болгож, эдлэлд шигтгээ хийх нь нэн баялаг болгосон байна. (зураг 20, 21)

Зураг 18, 19

Эсгэх, Сийлэх ба будаг оруулах



Зураг 20, 21

Хайчилбар, Шигтгээ шигтэх



Цүнхний ёроолыг хатууруулахын тулд арьсыг давхарласан нь оёход түвэгтэй байсан учир туршлагатай Монгол настны зөвлөсний дагуу монгол гутал уллах уламжлалт аргыг ашиглан оёсон. (Зураг 22)

Зураг 22

Оёж урлах



Дүгнэлт

1. Энэхүү гурван цуврал бүтээлийг хийх практик үйл ажиллагааны явцад бид эхэндээ цулгүй арьсан сийлбэрийн чадвараар голчилж, сүүлийн бүтээлүүддээ Монгол өндөр настуудын уламжлалт гар урлалд удаан жилийн сурч боловсорсон оёдлын ур чадвараас суралцсан нь үндэстний соёл, үзэл санаа, зан чанар гүн гүнзгий тусгалаа олсон гэж үзлээ.
2. Монгол үндэстний уламжлалт гар урлал болон арьсан урлал хослуулсан туршилтаас бүх төрлийн урлаг дангаар орших биш, үйл буюу ажилбарууд хоорондоо хамтарснаар бүтээлийн чанар улам сайжирч болохыг таньж мэдсэн.
3. Монгол үндэстний арьсан урлал бусад урлагаас салангид тусдаа оршиж чадахгүй. Хоорондоо зохицолдон хамт орших боломжтойгоос гадна урлагийн бүтээлийг сайжруулах эрэл хайгуул тасралтгүй хийж, түүнийгээ туршин бүтээлчээр ажилбал өнөөгийн хөгжлийн үед улам боловсронгуй болж, бүтээлийн үнэ цэнийг нэмэгдүүлж хөгжих боломжтой байна.
4. Эдгэр бүтээлийг хичээлийн хэрэглэгдэхүүн болгож ашиглаж мөн дотоод гадаадын үзэсгэлэнгүүдэд оролцож шагнал хүртсэн болно.

Ном зүй

- Амарбат. (1997). *Монгол үндэстний уран зургийн судлал*. Шебян: Ляонянгийн үндэстэний хэвлэлийн хороо
- Амарбат. (2007). *Монгол үндэстний гар урлал уран зураг*. Хөх хот: Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо
- Жан Доо И. (2003). *Загварын сэтгэлгээний танилт - гар урлал уран зургийн заан сургалтын нэгэн зангилаагийн асуудал*. Төсөвлөлийн урлаг. 02
- Цацралт. (2003). *Монгол үндэстний хатгамал гар урлал*. Дундад улсын үндэстний сонин. 8 дугаар хэвлэл
- Улаантуяа., Хайрхан. (2011). Монгол үндэстний хээ угалзын бүтцийн уг дүрсийн тухай задлалт — Монгол үндэстний хээ угалзын бүрэлдсэн аргын тухай өгүүлэх нь. *Урлагийн сүвэгчлэлт. 6 дугаар хугацаа*
- Шан Дан. (2010). *Монгол үндэсний арьсан биет урлагийн судалгаа*. Хөх хот:Өвөр Монголын их сургууль
- Жао Жен Лон. (2012). *Өвөр Монголын арьсан сийлбэр урлалын жуулчны бэлэг дурсгалын загвар, хэрэглээ*. Хөх хот:Өвөр Монголын Багшийн их сургууль
- Бай Сарна. (2013). *Монгол үндэстний уламжлалт арьсан эдлэлийг үйлдвэрлэх ур мэргэжил түүний гоо сайхны онцлог*. Хөх хот:Өвөр Монголын Багшийн их сургууль

An experimental study on how to integrate Mongolian traditional elements into national leather art design

Morigen.W*

Derartment of national handicraft, Art school,
Inner Mongolia University For Nationlities

Abstract

Leather arts are important kinds of traditional Mongolian national handicrafts. The culture has been developing and growing up in this era. Mongolian leather artists have to demonstrate our culture, its unique design solution and artistic work in the domestic and global market. Shandan 2010, Mongolian National leather arts tradition and development, Jao Jen Lon 2012, National culture handicraft ability and its worth study, The researchers did many surveys, some of them Bia Sarnaa, 2013, Mongolian traditional leather connection between nomadic culture and trade influence. However, the lack of use concepts of design, use of the traditional elements, and the upgrading of tools are relatively short. Therefore, I am writing this article to conduct experimental research on the Mongolian nation's leather art innovation in three aspects: the innovation of the Mongolian traditional arts and the traditional craftsmanship of the interdisciplinary and inventories of innovative research and development tools and innovations. Based on these aspects I have experienced innovations 'Continuation', 'Mother', 'leather handicraft is life decoration'. These creations used to learning materials and involved domestic or international exhibitions. I have studied that possibility to develop of Mongolian national leather arts design improvement also increase the value of the creations

Keywords

Mongolian ethnic arts and design concepts, innovations, traditional elements, tools, traditional crafts

* Corresponding author: morigen6666@163.com